


СУМЫН ЗАСАГ ДАРГА



БАТЛАВ:

Э.НАСАНЦОГТ

2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр

Өвөрхангай аймгийн Баян-өндөр сумын засаг даргын тамгын газар

**БАЯН-ӨНДӨР СУМЫН СӨББ-ЫН 2019 ОНД ХЭРЭГЛЭГДЭХ ХҮҮХДИЙН
ХООЛ, ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ҮНИЙН САНАЛ АВАХТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

БУМБАТ
2019 он

2018.01.28

**БАЯН-ӨНДӨР СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2019 ОНД ХЭРЭГЛЭГДЭХ
ХҮҮХДИЙН ХООЛ, ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр: БАЯН-ӨНДӨР СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
2019 ОНД ХЭРЭГЛЭГДЭХ ХҮҮХДИЙН ХООЛ, ХҮНСНИЙ
БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн дугаар: №ӨВАБАӨСЗДТГ/201912005

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Баян-Өндөр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 онд хэрэглэгдэх хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүн** нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтын Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50.000 *Итавин мянган*** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцно.

Байгууллагын нэр: Өв.Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар

Банкны нэр: Төрийн банк

Дансны дугаар: 100102055405

Тендерийг **2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 16 цаг 00** минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 16 цаг 30** минутад нээнэ.

Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар
10 тоот, Утас: 99884180

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах
эрх олгох
тухай
мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт |
|--------------------------------|--|
| ТӨӨЗ 1.1 | <ul style="list-style-type: none"> - Сүүлийн 1 /нэг/ жилийн санхүүгийн тайлан /2018 оны санхүүгийн тайлан/ - Ижил төстэй ажил гүйцэтгэсэн сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл: Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны аль нэг жилд ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагатай байх /гэрээний хуулбар/ - Сүүлийн 1 жилд ашигтай ажилласан байх ба борлуулалтын орлого нь тухайн багцад санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх - Бусад нэмэлт шаардлага; Харилцагч банкуудынөр, зээлгүй тодорхойлолт, ШШГАлба, Татвар, Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт, Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар - Тохирлын гэрчилгээтэй байна. /Хугацаа дуусаагүй, дор хаяж 1 жил байх/ |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендерт оролцогч нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Одоо хэрэгжиж байгаа ижил төстэй ажил гүйцэтгэж байгаа бол хэрэгжилтийн талаар захиалагч байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ. 2. Тендерт оролцогч нь боловсруулсан тендерийн иж бүрдэл, баримт бичгийг электрон хэлбэр /Adobe PDF/-т хөрвүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ. 3. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийн талаар санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлэх <p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж материалыг цахимаар авч, тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Цаг: 16 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn –ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p> |
| ТӨӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар, 10 тоот, Утас: 99884180 Огноо: 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Цаг: 16 цаг 30 минут</p> |
| ТӨӨЗ 6.1 | <p>Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p> |
| ТӨӨЗ 6.2 | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц-1: Сүү, сүүн бүтээгдэхүүн, төсөвт өртөг 5958900 төгрөг Багц-2: Махан бүтээгдэхүүн, төсөвт өртөг 15920000 төгрөг Багц-3: Хүнсний бүтээгдэхүүн, төсөвт өртөг 17927400 төгрөг</p> |

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

| Нэр | Тодорхойлолт | Тоо ширхэг | Х/н | ТШӨХ-Д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|---|---|--|---|--|---|--|--------------------------------------|
| | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| <i>Багц-1: Сүү, сүүн бүтээгдэхүүн</i> | <i>Сүү Хуурай сүү Тараг Аарц Ааруул Эзэгий Бяслаг</i> | <i>743 81 135 864 24 28 12</i> | <i>л кг л кг кг кг кг</i> | <i>Баян-Өндөр сумын СӨББ</i> | <i>Гэрээ хийсэн өдрөөс</i> | <i>Дараа оны тендер зарлагдах хүртэл</i> | |
| <i>Багц-2: Махан бүтээгдэхүүн</i> | <i>Үхэр Хонь</i> | <i>2160 1280</i> | <i>кг кг</i> | <i>Баян-Өндөр сумын СӨББ</i> | <i>Гэрээ хийсэн өдрөөс</i> | <i>Дараа оны тендер зарлагдах хүртэл</i> | |
| <i>Багц-3: Хүнсний бүтээгдэхүүн</i> | <i>Жагсаалтаар</i> | | | <i>Баян-Өндөр сумын СӨББ</i> | <i>Гэрээ хийсэн өдрөөс</i> | <i>Дараа оны тендер зарлагдах хүртэл</i> | |

Техникийн тодорхойлолт

| Багцийн дугаар | Бараа болон холбогдох үйлчилгээний нэр | Техникийн тодорхойлолт болон стандарт |
|-----------------------|---|--|
| <i>Багц-1</i> | <i>Сүү сүүн бүтээгдэхүүн</i> | - Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, ногоо, гурил гурилан бүтээгдэхүүнийг дотоодод үйлдвэрлэсэн /импортын бус/ бүтээгдэхүүн нийлүүлэх - Хугацаа дуусаагүй, чанарын баталгаатай байх |
| <i>Багц-2</i> | <i>Махан бүтээгдэхүүн</i> | |
| <i>Багц-3</i> | <i>Хүнсний бүтээгдэхүүн</i> | |

1. Баталгаат жин хэмжүүртэй байх /мэргэжлийн байгууллагын дүгнэлт бүхий/
2. Хүнсний материалын хэрэгцээг тасралтгүй хангаж байх
3. Махан бүтээгдэхүүн гарал үүслийн бичигтэй байх
4. Бараа бүтээгдэхүүний үнэ нь тухайн суманд мөрдөгдөж байгаа зах зээлийн хамгийн бага дундаж үнэ байх
5. Хугацаа дууссан бүтээгдэхүүн, чанарын шаардлага хангахгүй /норсон, хатсан, хөгцөрсөн, жин дутуу, гашилж ээдсэн зэрэг/ бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд үл маргах журмаар хэрэглэгчийг хохиролгүй болгоно гэсэн албан ёсны баталгаа ирүүлэх
6. Тухайн сарын хэрэгцээнээс шалтгаалан сарын төсвөөс хэтрэх тохиолдол гардаг учраас шаардлагатай хэрэгцээгээр тасралтгүй хангаж байх талаар баталгаа ирүүлэх
7. Бүтээгдэхүүний хэмжээг тодорхой зааж ирүүлэх

**БАЯН-ӨНДӨР СУМЫН СӨББ-ЫН ХҮҮХДИЙН ХООЛ, ХҮНСНИЙ МАТЕРИАЛЫН
ЗАХИАЛГА**

2019.01.07

| БАГЦ-1 Сүү, сүүн бүтээгдэхүүн | | | | | | | | | | | | | | | | | | |
|------------------------------------|------------------------------|---------------------------|---------------|-----------------------|-----------------------|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|--------|-------------------------------------|---|--|--|
| Д/Д | Бүтээгдэхүүний нэр | Бараа, Бүтээгдэхүүний нэр | Х/Н | Захиалсан тоо | Нийлүүлэлтийн хуваарь | | | | | | | | | | | | Гарал үүсэл | Чанарын шаардлага /техникийн тодорхойлолт/ |
| | | | | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 9 | 10 | 11 | 12 | | | | |
| 1 | Сүү сүүн бүтээгдэхүүний багц | Хуурай сүү | л | 81 | 15 | 15 | 15 | 18 | 18 | | | | | | Монгол малын түүнтэй дүйцэхүйц | Эрүүл ахуйн шаардлага хангасан, илчлэг сайтай, шинжилгээний бичигтэй | | |
| 2 | | Монгол сүү | л | 743 | | | | | | 63 | 170 | 170 | 170 | 170 | | | | |
| 3 | | Тараг | л | 135 | | | | 42 | 42 | 15 | 36 | | | | | | | |
| 4 | | Аарц | л | 864 | 96 | 96 | 96 | 96 | 96 | | 96 | 96 | 96 | 96 | | | | |
| 5 | | Ааруул | л | 24 | | | | | | | | 12 | 12 | | | | | |
| 6 | | Эзэгий | л | 28 | | | | | | | 7 | 7 | 7 | 7 | | | | |
| 7 | | Баяслаг | кг | 12 | | | | | | | | 6 | 6 | | | | | |
| Нийт дүн | | | | 5958900 | | | | | | | | | | | | | | |
| БАГЦ-2 Мах махан бүтээгдэхүүн | | | | | | | | | | | | | | | | | | |
| Бүтээгдэхүүний нэр | Бараа, бүтээгдэхүүний нэр | Х/Н | Захиалсан тоо | Нийлүүлэлтийн хуваарь | | | | | | | | | | | | Гарал үүсэл | Чанарын шаардлага /техникийн тодорхойлолт/ | |
| | | | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 9 | 10 | 11 | 12 | | | | | |
| Мах махан бүтээгдэхүүний | Үхрийн мах | л | 2.160 | 350 | 350 | 350 | 370 | 370 | | | | | | 370 | Монгол малын түүнтэй дүйцэхүйц | Эрүүл ахуйн шаардлага хангасан, илчлэг сайтай, тарган, гарал үүслийн болон шинжилгээний бичигтэй | | |
| | Хонины мах | л | 1.280 | | | | | | 200 | 360 | 360 | 360 | | | | | | |
| | Дүн | | 15920000 | | | | | | | | | | | | | | | |
| БАГЦ-3 Хүнсний бүтээгдэхүүний багц | | | | | | | | | | | | | | | | | | |
| № | Бүтээгдэхүүний нэр төрөл | Бараа, бүтээгдэхүүний нэр | Х/Н | Захиалсан тоо | Нийлүүлэлтийн хуваарь | | | | | | | | | | | | Гарал үүсэл | Чанарын шаардлага /техникийн тодорхойлолт/ |
| | | | | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 9 | 10 | 11 | 12 | | | | |
| 1 | Гурил, будааны бүтээгдэхүүн | Гурил | кг | 556 | 52 | 52 | 52 | 60 | 60 | 40 | | 60 | 60 | 60 | Монгол түүнтэй дүйцэхүйц /УБ гурил/ | Дээд зэргийн сортын илчлэг сайтай, савласан, он сар хугацаа нь ил тод тавигдсан, хадгалалт хамгаалалт сайн чийггүй байна. | | |
| 2 | | Каш | кг | 220 | 23 | 23 | 23 | 25 | 25 | 9 | 23 | 23 | 23 | 23 | | | | |
| 3 | | Цагаан будаа | кг | 958 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 40 | 10 | 10 | 10 | 10 | | | | |
| 4 | | Шар будаа | кг | 70 | 6 | 6 | 8 | 8 | 8 | 2 | 8 | 8 | 8 | 8 | | | | |
| 5 | | Гурвалжин будаа | кг | 48 | 6 | 4 | 6 | 6 | 6 | 2 | 4 | 4 | 6 | 6 | | | | |
| 6 | | Хөц будаа | кг | 18 | 2 | 2 | 2 | 2 | 2 | | 2 | 2 | 2 | 2 | | | | |
| 7 | | Гоймон | кг | 74 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 2 | 8 | 8 | 8 | 8 | Монгол түүнтэй дүйцэхүйц | | | |
| 8 | | Сахар | кг | 507 | 54 | 54 | 54 | 54 | 54 | 21 | 54 | 54 | 54 | 54 | | | | |
| 9 | | Талх | Ш | 306 | 34 | 34 | 34 | 34 | 34 | | 34 | 34 | 34 | 34 | | | | |
| 10 | Боов | уут | 294 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 24 | 30 | 30 | 30 | 30 | Монгол | | | | |
| 11 | Езвэн | уут | 232 | 24 | 24 | 24 | 24 | 24 | 16 | 24 | 24 | 24 | 24 | | | | | |
| 12 | Печень | ш | 2290 | 200 | 200 | 200 | 240 | 240 | 150 | 220 | 220 | 220 | 400 | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | | |
|--------|--|--------------|---------|----------------------|----|----|----|----|----|----|----|----|----|----|---------------------------|---|--|--|
| 1 3 | | Жигнэмэг | кг | 4 | | | | | | 4 | | | | | Түүнтэй дүйцэ хүйц | Гадны ямар нэгэн бохилдол ороогүй хальс шинэлэг ялзарч муудаагүй, дээд зэргийн сортоор эх орны хөрсөнд тарьж ургуулсан, шинжилгээний бичигтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан | | |
| 1 | Хүнсний ногоо | Төмс | кг | 298 | 32 | 32 | 32 | 32 | 32 | 10 | 32 | 32 | 32 | 32 | | | | |
| 2 | | Байцаа | кг | 233 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 8 | 25 | 25 | 25 | 25 | | | | |
| 3 | | Лууван | кг | 346 | 38 | 38 | 38 | 38 | 38 | 4 | 38 | 38 | 38 | 38 | | | | |
| 4 | | Сонгино | кг | 158 | 17 | 17 | 17 | 17 | 17 | 5 | 17 | 17 | 17 | 17 | | | | |
| 5 | | Сармис | кг | 18 | 2 | 2 | 2 | 2 | 2 | | 2 | 2 | 2 | 2 | | | | |
| 6 | | Чинжүү | кг | 140 | 10 | 10 | 18 | 18 | 18 | | 15 | 15 | 18 | 18 | | | | |
| 1 | Чихэр жимс, бусад хүнсний бүтээгдэхүүн | Масло | кг | 145 | 16 | 15 | 16 | 16 | 16 | 2 | 16 | 16 | 16 | 16 | Орос түүнтэй дүйцэ хүйц | Хугацаа дуусаагүй, чанарын шаардлага хангасан | | |
| 2 | | Ургамлын тос | кг | 156 | 17 | 17 | 17 | 17 | 17 | 3 | 17 | 17 | 17 | 17 | | | | |
| 3 | | Үзэм | кг | 66 | 7 | 7 | 7 | 7 | 7 | 3 | 7 | 7 | 7 | 7 | | | | |
| 4 | | Варень | кг | 36 | 4 | 4 | 4 | 4 | 4 | | 4 | 4 | 4 | 4 | | | | |
| 5 | | Чихэр | кг | 200 | 21 | 20 | 21 | 21 | 21 | 12 | 21 | 21 | 21 | 21 | | | | |
| 6 | | Витамин | уу т | 830 | 90 | 90 | 93 | 93 | 93 | | 92 | 93 | 93 | 93 | Монгол түүнтэй дүйцэ хүйц | ахуйн шаардлага хангасан, хугацаа нь дуусаагүй, шинжилгээний бичигтэй | | |
| 7 | | Жүүс | л | 172 | | | | 36 | 36 | 64 | 36 | | | | | | | |
| 8 | | Чацаргана | л | 31 | 8 | | | 8 | | | 7 | | 8 | | | | | |
| 9 | | Нэрс | л | 47 | | 8 | 8 | | 8 | | | 7 | 8 | 8 | | | | |
| 10 | | Перец | ш | 38 | 4 | 4 | 4 | 4 | 4 | 2 | 4 | 4 | 4 | 4 | | | | |
| 11 | Давс | ш | 47 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 2 | 5 | 5 | 5 | 5 | | | | | |
| 12 | Цай | ш | 10 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | | | | | |
| | Дүн | | | 1792740 0 | | | | | | | | | | | | | | |

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|---|-----------------------|---------------------------|-------------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд |

**биелүүлээгүй
-гээс гэрээг
цуцлах**

захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

**11.Маргааныг
шийдвэрлэх**

11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг ____ оны __ дугаар сарын ____-наас ____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]